



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/207-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: <a href="mailto:infoauditselenge@gmail.com">infoauditselenge@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

САЙХАН СУМЫН НОМГОН ТОСГОНЫ  
ДӨРӨВДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.АРИУНЖАРГАЛ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/207-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 7,383.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд

суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 85.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>43,529,719.92</b>	<b>106,520,698.20</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>10,840,497.80</b>	<b>66,548,504.08</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>10,840,497.80</b>	<b>66,548,504.08</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>10,840,497.80</b>	<b>66,548,504.08</b>
31211	Төрийн сангийн харилцах	10,840,497.80	66,548,504.08
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>32,689,222.12</b>	<b>39,972,194.12</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	88,500.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>32,689,222.12</b>	<b>39,883,694.12</b>
35410	Бичиг хэргийн материал	103,500.00	18,000.00
35420	Аж ахуйн материал	10,779,985.85	10,950,985.85
35450	Барилгын засварын материал	-	3,215,000.00
35460	Хүнсний материал	63,215.00	195,087.00
35470	Бусад хангамжийн материал	21,742,521.27	25,504,621.27
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>470,884,273.31</b>	<b>441,540,009.72</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>470,884,273.31</b>	<b>441,540,009.72</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>461,862,273.19</b>	<b>432,768,009.47</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	496,257,205.85	496,257,205.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(58,456,510.38)	(82,115,325.30)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	35,132,265.00	36,482,665.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,948,385.12)	(24,422,544.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,456,567.28	16,016,567.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,828,716.96)	(13,112,906.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,265,070.00	10,265,070.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,152,569.48)	(8,740,069.44)
39217	Ном	2,137,347.00	2,137,347.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>9,022,000.12</b>	<b>8,772,000.25</b>
39301	Программ хангамж	1,450,000.00	1,450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(949,999.88)	(1,199,999.75)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,522,000.00	8,522,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>514,413,993.23</b>	<b>548,060,707.92</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,681,534.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,681,534.00</b>	-
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>9,681,534.00</b>	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,681,534.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>504,732,459.23</b>	<b>548,060,707.92</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>504,732,459.23</b>	<b>548,060,707.92</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	111,097,511.30	111,097,511.30
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	111,097,511.30	111,097,511.30
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>95,686,988.64</b>	<b>139,015,237.33</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(416,913,743.59)	95,686,988.64
51220	Тайлант үеийн үр дүн	512,600,732.23	43,328,248.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	297,947,959.29	297,947,959.29
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>514,413,993.23</b>	<b>548,060,707.92</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>977,915,046.22</b>	<b>607,696,907.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>529,746,446.22</b>	<b>4,628,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>529,746,446.22</b>	<b>4,628,400.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	495,289,340.35	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	34,457,105.87	4,628,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>448,168,600.00</b>	<b>603,068,507.28</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>383,786,100.00</b>	<b>541,459,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	383,786,100.00	541,459,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>64,382,500.00</b>	<b>61,608,907.28</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,382,500.00	61,608,907.28
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>465,314,313.99</b>	<b>564,368,658.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>465,314,313.99</b>	<b>564,368,658.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>465,314,313.99</b>	<b>559,569,243.59</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>308,540,168.88</b>	<b>373,724,849.66</b>
210101	Үндсэн цалин	212,041,776.32	261,766,793.97
210102	Нэмэгдэл	66,782,075.43	94,926,043.36
210104	Урамшуулал	5,486,774.13	17,032,012.33
210105	Гэрээт ажлын хөлс	24,229,543.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,063,579.32</b>	<b>46,978,419.06</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,729,216.32	33,172,249.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,977,795.00	3,392,855.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,572,670.00	2,820,376.00
210204	Ажилгүйдлийн даатгал	616,719.00	690,204.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,167,179.00	6,902,735.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,670,561.00</b>	<b>39,588,663.28</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,681,800.00	6,599,904.28
210302	Түлш, халаалт	28,612,873.00	28,612,871.00
210303	Цэвэр, бохир ус	4,375,888.00	4,375,888.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,539,092.75</b>	-
210408	Бараа материал акталсны зардал	3,539,092.75	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,299,715.00</b>	<b>43,618,738.00</b>
210502	Хоол, хүнс	37,299,715.00	43,618,738.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,100,000.00</b>	<b>9,123,710.00</b>
210604	Урсгал засвар	1,100,000.00	9,123,710.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>450,000.00</b>	<b>738,400.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	738,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35,651,197.04</b>	<b>45,796,463.59</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,231,200.00	12,205,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,014,930.00	2,336,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,405,067.04	31,254,663.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>4,799,415.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>4,799,415.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,799,415.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>512,600,732.23</b>	<b>43,328,248.69</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>512,600,732.23</b>	<b>43,328,248.69</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>448,168,600.00</b>	<b>603,068,507.28</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>448,168,600.00</b>	<b>603,068,507.28</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>383,786,100.00</b>	<b>541,459,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	383,786,100.00	541,459,600.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>64,382,500.00</b>	<b>61,608,907.28</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,382,500.00	61,608,907.28
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>437,328,102.20</b>	<b>545,450,101.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>437,328,102.20</b>	<b>545,450,101.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>437,328,102.20</b>	<b>540,650,686.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>308,531,969.20</b>	<b>373,724,849.66</b>
210101	Үндсэн цалин	212,655,208.64	258,876,734.66
210102	Нэмэгдэл	68,479,628.43	97,816,102.00
210104	Урамшуулал	5,486,774.13	17,032,013.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,910,358.00	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,063,579.00</b>	<b>46,978,419.06</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,729,216.00	33,172,249.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,977,795.00	3,392,855.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,572,670.00	2,820,376.00
210204	Ажилгүйдлийн даатгал	616,719.00	690,204.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,167,179.00	6,902,735.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,857,300.00</b>	<b>49,270,197.28</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,681,800.00	6,599,904.28
210302	Түлш, халаалт	26,799,612.00	38,294,405.00
210303	Цэвэр, бохир ус	4,375,888.00	4,375,888.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>37,099,324.00</b>	<b>43,750,610.00</b>
210502	Хоол, хүнс	37,099,324.00	43,750,610.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,100,000.00</b>	<b>12,338,710.00</b>
210604	Урсгал засвар	1,100,000.00	12,338,710.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>450,000.00</b>	<b>738,400.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	738,400.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,225,930.00</b>	<b>13,849,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,026,000.00	11,634,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,199,930.00	2,215,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>4,799,415.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>4,799,415.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,799,415.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>10,840,497.80</b>	<b>57,618,406.28</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>-</b>	<b>1,910,400.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>1,910,400.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>1,910,400.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,910,400.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-</b>	<b>(1,910,400.00)</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>10,840,497.80</b>	<b>55,708,006.28</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,840,497.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,840,497.80	66,548,504.08

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	111,097,511.30	297,947,959.29	(416,913,743.59)	(7,868,273.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	111,097,511.30	297,947,959.29	(416,913,743.59)	(7,868,273.00)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	512,600,732.23	512,600,732.23
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	111,097,511.30	297,947,959.29	95,686,988.64	504,732,459.23
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	111,097,511.30	297,947,959.29	95,686,988.64	504,732,459.23
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	111,097,511.30	297,947,959.29	95,686,988.64	504,732,459.23
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	43,328,248.69	43,328,248.69
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	111,097,511.30	297,947,959.29	139,015,237.33	548,060,707.92

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>615,676,200.00</b>	<b>547,360,501.00</b>	<b>68,315,699.00</b>	<b>88.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>615,676,200.00</b>	<b>547,360,501.00</b>	<b>68,315,699.00</b>	<b>88.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>610,876,700.00</b>	<b>542,561,086.00</b>	<b>68,315,614.00</b>	<b>88.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>423,864,200.00</b>	<b>373,724,849.66</b>	<b>50,139,350.34</b>	<b>88.2</b>
210101	Үндсэн цалин	283,840,600.00	258,876,734.66	24,963,865.34	91.2
210102	Нэмэгдэл	124,301,700.00	97,816,102.00	26,485,598.00	78.7
210104	Урамшуулал	15,721,900.00	17,032,013.00	(1,310,113.00)	108.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,773,300.00</b>	<b>46,978,419.06</b>	<b>14,794,880.94</b>	<b>76.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	42,005,500.00	33,172,249.06	8,833,250.94	79.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,941,900.00	3,392,855.00	1,549,045.00	68.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,954,200.00	2,820,376.00	1,133,824.00	71.3
210204	Ажилгүйдлийн даатгал	988,300.00	690,204.00	298,096.00	69.8
210205	Эрүүл мэндийн даатгал	9,883,400.00	6,902,735.00	2,980,665.00	69.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,040,800.00</b>	<b>49,270,197.28</b>	<b>1,770,602.72</b>	<b>96.5</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,370,400.00	6,599,904.28	1,770,495.72	78.8
210302	Түлш, халаалт	38,294,400.00	38,294,405.00	(5.00)	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,376,000.00	4,375,888.00	112.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,346,700.00</b>	<b>43,750,610.00</b>	<b>1,596,090.00</b>	<b>96.5</b>
210502	Хоол, хүнс	45,346,700.00	43,750,610.00	1,596,090.00	96.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,339,300.00</b>	<b>12,338,710.00</b>	<b>590.00</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	12,339,300.00	12,338,710.00	590.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>738,400.00</b>	<b>738,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	738,400.00	738,400.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,774,000.00</b>	<b>15,759,900.00</b>	<b>14,100.00</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,558,900.00	13,544,800.00	14,100.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,215,100.00	2,215,100.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,799,500.00</b>	<b>4,799,415.00</b>	<b>85.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,799,500.00</b>	<b>4,799,415.00</b>	<b>85.00</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,799,500.00	4,799,415.00	85.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>615,676,200.00</b>	<b>603,068,507.28</b>	<b>12,607,692.72</b>	<b>98.0</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>541,459,600.00</b>	<b>541,459,600.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	541,459,600.00	541,459,600.00	-	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>63,380,100.00</b>	<b>61,608,907.28</b>	<b>1,771,192.72</b>	<b>97.2</b>
320001	Орон нутгийн төсвөөс	63,380,100.00	61,608,907.28	1,771,192.72	97.2
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>10,836,500.00</b>	<b>-</b>	<b>10,836,500.00</b>	<b>-</b>
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	10,836,500.00	-	10,836,500.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,840,497.80	(10,840,497.80)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	66,548,504.08	(66,548,504.08)	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэг нь “Хүүхдээ дээдлэн багшаа хөгжүүлж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж бага насны хүүхдийг хөгжил төлөвшилтэй төдийгүй эрүүл чийрэг, эерэг зөв хандлага хүмүүжилтэй эх оронч үндэсний бахархалтай иргэн болгож хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрд зөв дадал хэвшлийг эзэмшүүлэх,
- Хүүхэд бүр баяр хөөртэй хайр халамжтай эелдэг харилцаатай байх,
- Хүүхэд бүр чөлөөт сонголт, амьд орчинд тоглох,
- Хүүхэд бүхэнд би чадна гэсэн итгэл өгөх,
- Хүүхэд бүрийн авьяасыг судалж хөгжүүлэх

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд батлагдсан,
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1. "ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2. "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,646.7 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,840.5	66,548.5	55,708.0
Авлага	-	-	-
Бараа материал	32,689.2	39,972.2	7,283.0
Үндсэн хөрөнгө	470,884.3	441,540.0	(29,344.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>514,414.0</b>	<b>548,060.7</b>	<b>33,646.7</b>
Өр төлбөр	9,681.5	-	(9,681.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	504,732.5	548,060.7	43,328.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>514,414.0</b>	<b>548,060.7</b>	<b>33,646.7</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 66,548.5 мянган төгрөг болж 55,708.0 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 39,972.2 мянган төгрөг болж 7,283.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 62,120.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, “Зоос Номгон” ХХК-аас 1,000.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, эцэг эхчүүдээс 3,628.4 мянган төгрөгийн хичээлийн хэрэгсэл, ахуйн хэрэгсэл үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 59,466.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 441,540.0 мянган төгрөг болж 29,344.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1,350.4 мянган төгрөгийн принтер, тоос сорогч, 560.0 мянган төгрөгийн баримт үдэгч, хүүхдийн утлагын аппарат зэрэг хөрөнгүүдийг худалдан авч, 31,254.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 558,743.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 53,742.1 мянган төгрөг нийт 612,485.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 207,039.5 мянган төгрөгөөр бууруулж 351,703.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 9,638.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 63,380.1 мянган төгрөгөөр, нийт 415,083.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 200,592.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 552,296.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 63,380.1 мянган төгрөгөөр нийт 615,676.2 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 552,296.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 63,380.1 мянган төгрөг, нийт 615,676.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 547,360.5 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн санхүүжилт 1,771.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 66,544.5 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 547,360.5 мянган төгрөг буюу 88.9 хувьтай байгаа нь эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 7.6 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 1,596.1 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 3.6 мянган төгрөгөөр, боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 48,735.9 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн зардлыг 16,201.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>552,296.1</b>	<b>485,751.6</b>	<b>66,544.5</b>	<b>88.0</b>
81605 - Эрүүл мэндийг дэмжих	1,162.6	1,155.0	7.6	99.3
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	45,346.7	43,750.6	1,596.1	96.5
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,262.1	2,262.1	-	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	1,369.6	1,366.0	3.6	99.7
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	355,462.5	306,726.6	48,735.9	86.3
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	146,692.6	130,491.3	16,201.3	89.0
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>63,380.1</b>	<b>61,608.9</b>	<b>1,771.2</b>	<b>97.2</b>
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	63,380.1	61,608.9	1,771.2	97.2
<b>ДҮН</b>	<b>615,676.2</b>	<b>547,360.5</b>	<b>68,315.7</b>	<b>88.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэг хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын онцгой журам харьцуулалтын аргаар гүйцэтгэсэн боловч оролцогч ирээгүй тул “Ханангийн хөх бууц” ХХК, “Сүүн зам дейри” ХХК -тай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 465,314.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,979.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сайхан сумын Номгон тосгоны дөрөвдүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 23/58 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,372.2 мянган төгрөгийн төсөвт тусгагдаагүй зардал гаргаж илүү цагийн хөлсийг нэмэгдүүлэн олгосон зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	3,372.2	1	3,372.2	100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>3,372.2</b>	<b>1</b>	<b>3,372.2</b>	<b>100.0</b>

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “ Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу нягтлан бодогч Д.Тунгалагт ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **1,114.0** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15

дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **1,871.8** мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрч төлбөрийн акт тогтоолоо.

### 5.1 Төлбөрийн акт

1. Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр шаардлага хангасан багш нарт 1,871.8 мянган төгрөгийн урамшууллыг тогтоосон хувь хэмжээнээс илүү бодож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх “...багшийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн багшид Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд заасан мөнгөн урамшууллыг доор дурдсан хувь хэмжээгээр албан тушаалын сарын үндсэн цалингаас тооцож олгоно. “III түвшин 15%”, “IV түвшин 10%” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшууллыг тогтоосон хувь хэмжээнээс илүү олгосон	1	1,871.8	1	1,871.8								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,871.8</b>	<b>1</b>	<b>1,871.8</b>								

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
<b>Дүн</b>											
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
<b>Дүн</b>											
<b>Нийт дүн</b>											